ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН**
# ТУШААЛ

2021 оны 09 сарын 10 өдөр | Дугаар А/337 | Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 3.1.1 дэх заалт, Стандарт хэмжил зүйн газрын "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага, MNS ISO/IEC 17025:2018" стандартын 4.1.2, 7.2.1.6, 7.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн албаны лабораторийн хэсгийн үйл ажиллагааг шударга, үнэн зөв, бодитой явуулах зорилгоор "Лабораторийн ажилтны шударга байдлын журам 04_ЛАБ-ЖУР13(2.0)"-ыг нэгдүгээр хавсралтаар, лабораторийн "Чанарын бодлого"-ын өөрчлөлтийг хоёрдугаар хавсралтаар, "Сорилтын арга боловсруулж, баталгаажуулах журам. 04_ЛАБ-ЖУР22(1.0)"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журам, чанарын бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн алба (Б.Борхүү)-нд үүрэг болгосугай.

3. Дээрх журам, чанарын бодлогыг мөрдөж ажиллахыг лабораторийн хэсгийн нийт ажилтнуудад, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн албаны Захиргаа, санхүүгийн хэсэг (Г.Төмөрсүх)-т даалгасугай.

ДАРГА П.МӨНХЖАРГАЛ

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2021 оны ..09.. дүгээр сарын ..10..-ны өдрийн
А/337 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

УЛААНБААТАР ХОТ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
9020051071 ☏ 6577539

ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

# ЛАБОРАТОРИЙН АЖИЛТНЫ ШУДАРГА БАЙДЛЫН ЖУРАМ

Баримт бичгийн дугаар: **04_ЛАБ-ЖУР13(2.0)**
Хувилбарын дугаар: **2.0**
Хэвлэсэн огноо: **2021 он 08 сар 23 өдөр**
Хүчин төгөлдөр болсон огноо: **2021 он 09 сар 10 өдөр**

| Баримт бичгийг хариуцах нэгж | **ШИНЭ НИСЭХ БУУДЛЫН ШАТАХУУН ХАНГАМЖИЙН АЛБА – Шатахууны чанар хяналтын лаборатори** | | |
|---|---|---|---|
| Баримт бичгийн ангилал: | НЭЭЛТТЭЙ | Баримт бичгийн түвшин | 2 |

| | Нэр | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|---|
| БАТАЛСАН: | Б.БОРХҮҮ | ДАРГА | |
| ХЯНАСАН: | Г.ТӨМӨРСҮХ | ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭСГИЙН ДАРГА | |
| | П.ЧИНЗОРИГ | ЧАНАРЫН МЕНЕЖЕР | |
| БОЛОВСРУУЛСАН: | П.ЗОЛЖАРГАЛ | АХЛАХ ИНЖЕНЕР ХИМИЧ | |

## Баримт бичгийн өөрчлөлт

| Хувилбарын дугаар | Хүчин төгөлдөр болсон огноо | Өөрчлөлтийн утга | Өөрчлөлт оруулсан ажилтны нэр, албан тушаал | Өөрчлөлт оруулсан ажилтны гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1.0 | 2021.03.26 | Анхны хувилбар | | |
| 2.0 | 2021.09.10 | – Журмын нүүрэнд баримт бичгийн хариуцах нэгжийг “Шатахуун хангамжийн байгууламж” гэж бичсэнийг “Шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн алба” болгож өөрчилсөн.<br>– Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангамжийн албаны логог Иргэний нисэхийн үндэсний төвийн логогоор сольсон.<br>– Журмын толгойд “Чингис хаан олон улсын нисэх буудал дахь шатахуун хангамжийн байгууламж” гэж бичсэнийг “Шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн алба” болгож өөрчилсөн.<br>– “Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба” гэж бичсэнийг “Шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн алба” болгож өөрчилсөн.<br>– Журмын бүх хэсэгт “Химич инженер” гэж бичсэнийг “Инженер химич” болгож өөрчилсөн.<br>– 2.1 заалтад “... үйл ажиллагаа явуулах болон ижил төстэй ...”, “...лабораторийн нийт ажилтнууд дагаж мөрдөнө.” гэж тус тус нэмсэн.<br>– 4-р бүлгийн Үйл ажиллагааны матрицад “ШХБ-ийн хэсгийн дарга” гэж бичсэнийг “Дарга” гэж өөрчилсөн.<br>– 4-р бүлгийн Үйл ажиллагааны матрицад “Захиргаа, санхүүгийн хэсгийн дарга”, “Чанарын менежер” багана нэмсэн.<br>– 4.2 заалтад “Байгууллагын дотоод журам” гэж бичсэнийг “Хөдөлмөрийн дотоод журам” гэж өөрчилсөн.<br>6.1 заалтад “Лабораторийн ажиллагсад ашиг сонирхлын зөрчилгүй, шударга ажиллана гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана” гэж бичсэнийг хассан. | Ахлах инженер химич П.Золжаргал | |